


ТАЛСТ МОЛОР ХХК



**ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГ
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЦОГ ХАД” НЭРТЭЙ ГЯНТБОЛДЫН
ҮНДСЭН ОРДЫГ ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот 2026 он

АГУУЛГА

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1Төслийн нэр	3
1.2Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж:	3
1.3Төслийн байршил	3
2 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
2.1Ордын дэд бүтэц зам харилцаа:	5
2.2Уурхайн барилга байгууламж	6
2.3Цахилгаан хангамж	8
2.4Усан хангамж	9
2.5Зам харилцаа	9
3 ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
3.1Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл	10
3.2Газрын гадарга, хэвлий түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл	10
3.3Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	11
3.4Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл	11
4 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	12
5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
6 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
7 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
8 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
9 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
10 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
11 ХОГ, ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
12 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	21
13 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
14 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУТЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
15 ХАВСРАЛТ	25

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Талст молор” ХХК нь 2013 онд Геологийн суурь судалгаа хийх үндсэн үйл ажиллагааны чиглэлтэйгээр байгуулагдсан. 2015 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 886 тоот шийдвэрээр XV-019692 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл 3 жилийн хугацаатай олгогдсон. Улмаар талбайн хэмжээнд судалгаа хийж Хар дав гэх нэртэй гянтболдын хэтийн төлөв сайтай илрэл дээр үндсэн хайгуулын ажлыг 2015-2017 онуудад өөрийн хөрөнгөөр хайгуул хийж гянтболдын үндсэн ордыг нээн илрүүлж гянтболдын нөөцийг үйлдвэрлэлийн “В” зэргээр бодитой нөөцийг 0.36% -ийн дундаж агуулгатайгаар 147.4 тн, “С” зэргээр боломжтой нөөцийг 0.49% -ийн дундаж агуулгатайгаар 312.5 тн, “Р₁” зэргээр илрүүлсэн баялгийг 0.28% -ийн дундаж агуулгатайгаар 386.46 тн, “Р₂” зэргээр таамгалсан баялгийг 0.89% -ийн дундаж агуулгатайгаар 21.47 тн –оор, нийт В+С зэргээр 459.90 тн, баялгийг Р₁+Р₂ зэргээр 407.93 тн –оор тооцон “Оцог хад”-ны гянтболдын ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар батлуулж, эрдэс баялгийн нэгдсэн санд бүртгүүлсэн.

2017 оны 09 сарын 28-ны өдөр Ховд аймгийн Алтай сумын нутагт орших 407.99 га бүхий “Богоч” нэртэй талбайд АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр MV-020930 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон.

Тус ордыг ашиглах “Техник эдийн засгийн үндэслэл” /ТЭЗҮ/-ийг “ЖИ ЭМ ПРОЖЕКТ” ХХК боловсруулсан байна. Тус ТЭЗҮ-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 14-10-06 тоот дүгнэлтээр баталгаажуулсан байна. Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7-р зүйлд заасны дагуу тус төслийн Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг БОАЖЯ-аас 2017 оны 09-р сарын 05-ны өдөр гаргасан байна.

Төслийн гол зорилго нь “Оцог хад нэртэй гянтболдын үндсэн ордыг далд аргаар ашиглах” техник эдийн засгийн үндэслэлээр тус ордыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар далд аргаар олборлох, зах зээлд борлуулахад тус төслийн зорилго оршино. Төслийн үргэлжлэх хугацаа 5 жил болно.

1.1 Төслийн нэр

“Оцог хад” гянтболдын үндсэн ордыг далд аргаар ашиглах төсөл

1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж:

Байгууллагын нэр: “Талст молор” ХХК

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011444150

Регистрийн дугаар: 5774047

Бүртгүүлсэн огноо: 2013.11.26

Байгууллагын хаяг: УБ хот, ХУДүүрэг, 11-р хороо, Зайсан гудамж, Golden Buddha, 15Б байр, 52А тоот

Холбоо барих утас: +976-77112257, 99010431, 99165454

И-майл: talst.molor@yahoo.com

1.3 Төслийн байршил

“Талст молор” ХХК нь Ховд аймгийн Алтай сумын нутаг дэвсгэрт байрлах "Оцог

хад" гянтболдын үндсэн ордод олборлолтын үйл ажиллагааг явуулж байна. Тус орд нь Алтай, Үенч сумдын хилийн дагуу орших ба Алтай суманд харъяалагддаг бөгөөд Улаанбаатар хотоос баруун урд зүгт 1620 км-т, Алтай сумын төвөөс баруун хойд зүгт 60 км-т, Үенч сумын төвөөс зүүн хойд зүгт 45 км-т Бодонч голын сав газарт байрлана.


Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь 407.99 га. Төслийн талбайн солбицолын цэгүүдийг Хүснэгт 1-д, байршлыг Зураг 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол

Д/Д	Уртраг			Өргөрөг		
	градус	Минут	секунд	градус	минут	секунд
1	92	18	38.24	46	18	35.23
2	92	16	25.15	46	18	35.23
3	92	16	37.17	46	18	57.37
4	92	16	53.34	46	19	27.17
5	92	18	38.24	46	19	27.17

Талбайн хэмжээ: 407.99 га болно.

МV-020930 ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН БАЙРШЛЫН ЗУРАГ



Зураг 1. Оцог хад уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн байршил

2 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Ордын дэд бүтэц зам харилцаа:

Ховд аймгийн Алтай, Үенч сумдын нутаг дэвсгэрийн заагт орших ба Алтай суманд хамаарна. Тус сумын төвүүдэд аж ахуйн үйлчилгээний барилга байгууламж, бүх үүрэн телефоны сүлжээ ашигладаг, холбоо, банк, сургууль, эмнэлэг, шатахуун түгээх станцууд болон бусад орон нутгийн албууд ажилладаг.

Алтай сумын төвөөр Ховд-Ярант, Хөшөөт-Ярантын боомтыг холбосон хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг. Үенч сумын төвд Үенчийн голд усан цахилгаан станц ажилладаг бөгөөд ойролцоох зарим сумдыг эрчим хүчээр хангадаг. Энэ станц нь улиралын чанартай ажилладаг бөгөөд сүүлийн 3-4 жил хэвийн ажиллагаа нь алдагдаж доголдол их гарч байгаа.

2.2 Уурхайн барилга байгууламж

Оцог хад гянтболдын үндсэн ордын уурхайд дараах барилга байгууламжууд байна. Үүнд:

- Уурхайн ажилчдын хотхон (10 ш гэр, 12 ш сэндвичин байр)
- Уурхайн оффис (40 тн-ын 1 ш контейнер)
- Тэсрэх материалын агуулах (20 тн-ын 2 ш контейнер)
- Баяжуулах үйлдвэр
- Хоолны газар
- Угаалгын газар
- Авто засварын газар
- Бусад туслах материалын агуулах зэрэг орно.

Үйлдвэрийн барилга байгууламж. Барилгын суурийн хөрсний шинжилгээ, барилгын зураг төсөл, нарийвчилсан зохиомж гаргах ажлуудын үндсэн дээр барьж байгуулах нь зүйтэй.

Уурхайн оффис, ажиллагсдын байр хоол амралтын газар. Уурхайн оффис, ажиллагсдын амрах байр болон хоолны заал, ажиллагсдын чөлөөт цагаа өнгөрүүлэх заал зэрэг байрууд нь сэндвичэн барилгууд байна. Хоолны заал нь нэг зэрэг 25 хүн хүлээн авах хүчин чадалтай бөгөөд харин ажиллагсдын амрах байр нь 4 хүний амрах зориулалт бүхий 11 тасалгаатай, дотроо ариун цэврийн болон угаалгын өрөөтэй тус бүр 2 байртай ба нийт 56 хүн нэг зэрэг байрлах боломжтой юм.

Уг байр нь галын болон агааржуулалтын сүүлийн үеийн технологи бүхий тоноглолоор бүрэн тоноглогдсон ажиллагсдын амрах тав тухыг бүрэн хангана.

Фото зураг 1. Уурхайн ажилчдын хотхон



Түлшний агуулах. Түлшний агуулах нь уурхайн зүүн урд 0.8 км зайд байрлана. Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний агуулахад 50 тн багтаамжтай 1 зөөврийн агуулах байна. Агуулах нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж өгнө.

ШТМ –ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.



Фото зураг 2. Уурхайн ШТМ –ын агуулах

Тэсрэх материалын агуулах. Уурхайн талбайгаас зүүн хойд талд 0.5 км зайд тэсрэх материалын агуулах байрлана. Агуулах нь үер усны шуудуугаар хамгаалагдсан төмөр торон хашаагаар хүрээлэгдсэн талбайд байрлах ба шалгах пункт, харуулын байртай байна. Агуулахыг тойруулан хамгаалалтын шороон далан байгуулж, аянга зайлуулагчаар тоногдосон. Тэсрэх материалын агуулахад тус бүр 20 тоннын багтаамжтай тэсрэх бодисын 1 чингэлэг, тэсэлгээний материалын 1 чингэлэг, гал унтраах хэрэгсэл, усны сав байна. ТБ-ыг ашиглах, хадгалах, түгээх, тээвэрлэх ажлыг ТБ –той харьцах норм дүрмийн дагуу явуулна. ТБ –ын агуулахыг аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу осол аварггүй зайд байрлуулж харуул хамгаалалтаар хангасан байна. ТБ-ын агуулахын байршлыг уурхайн дэвсгэр зурагт үзүүлсэн.

Засварын төв, автограж. Уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг өөрийн засварын цехэд хийж гүйцэтгэнэ. Засварын цех нь уурхайн кемпийн дэргэд байрлана. Засварын цехэд дугуй засвар, гагнуур, кран, компрессорын станц, кран тайл, токер, зэргийг байгуулна. Уурхай, боловсруулах хэсгийн төхөөрөмжүүд, технологийн автомашин, үйлчилгээний автомашин зэргийг засварлах болно.

Сэлбэг материалын агуулах. Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтэцээс хамааруулан сэлбэг материал, хэрэгсэлийн агуулахыг 40 тн –ын багтаамжтай чингэлэгээр тохижуулсан.

Баяжуулах үйлдвэр: 2016 онд “Талст молор” ХХК нь хүдрийн биетүүдээс лабораторийн баяжуулах технологийн туршилтад 350 кг хүдэр авч шинжлүүлсэн байна. Хүдрийг -5 мм хүртэл буталсны дараагаар дээжийг конус-цагирган аргаар 3 удаа хольж хутгасны дараагаар ½ -ийг -1 мм хүртэл буталж, үлдсэн ½ -ийг (-5 мм-ийн ангиллын дээж) Джонсон хуваагч ашиглан 1 кг болтол хольж багасган, анхдагч шигшүүрийн шинжилгээ хийж гянтболдын агуулгыг тодорхойлсон байна. Ашиглалтын хугацаанд ил далд уурхайгаас олборлосон нийт 93.87 мян.тн хүдрийг гравитацийн аргаар баяжуулахад ашиглалтын нийт жилд 65.86%-ийн агуулгатай баяжмал гаргана.



Фото 3. Баяжуулах үйлдвэр

2.3 Цахилгаан хангамж

Тус уурхай нь уурхайн өөрийн цахилгаан эрчим хүчийг зөөврийн дизель цахилгаан үүсгүүрээр эрчим хүчний хэрэгцээг ханган ажиллаж байна.



Фото 4. Уурхайн цахилаан үүсгүүр

Уурхайн цахилгаан хэрэглэгч нь 1. Далд уурхайн олборлолтын тоног төхөөрөмж; 2. Компрессорын станц; 3. Далд уурхайн гэрэлтүүлэг; 4. Тэсрэх материалын агуулах; 6. Уурхайн тосгон, 7. Баяжуулах цех зэрэг байна.

2.4 Усан хангамж

Уурхайн ажилчдын хотхоны унд-ахуйн усны хэрэгцээг гадаргын усаар хангаж байна. Баяжуулах үйлдвэрийн технологийн усыг гадаргын усаар зөөвөрлөж хангах ба замын тоосжилтыг дарахад мөн гадаргын ус, шүүрлийн усыг ашигладаг.

Уурхайн усны хэрэгцээг хангахад шаардлагатай усны ундарга нь 1.58 л/сек байна. Ордоос 14 км Хөндийн гол, 7 км-ийн зайд байх Нүцгэний голоос технологийн болон ундны усаа зөөврөөр авч хэрэглэнэ. Уурхайн ашиглалтын үед цэвэр усны үндсэн хэрэглэгчид нь хүдэр баяжуулах үйлдвэр, далд уурхай, ажилчдын хотхон байна. Уурхайд хэрэглэх усыг зориулалтаар нь технологийн, техникийн, унд ахуйн хэрэглээний ус болон бусад хэрэглээний ус гэж ялган, уурхайд нийтэд нь шаардлагатай усны хэмжээг тооцоолсон болно.



2.5 Зам харилцаа

Зам харилцааны хувьд төвийн районоос нилээд алслагдсан боловч авто тээвэр, агаарын тээвэр амжилттай хөгжиж байна. Хөрш Булган сум Улаанбаатартай агаарын замаар холбогддог ч одоогийн байдлаар нислэг хийгдэхгүй байна. Хүн амын хувьд 1 км² нутаг дэвсгэрт 0.5-5 хүн ноогддог байна. Оцог хад уурхайгаас бусад сум, хот, суурин газрууд уруу шороон зам, засмал замаар холбогддог. Ил уурхайн дотоод замыг үйлдвэрлэлийн хаягдал болох эфель, галь зэргээр хучиж, сайжруулалт, арчилгааг тогтмол хийж байна.

3 ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн зүгээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг усан орчин, агаар мандал, хөрс ургамалын орчинд үзүүлэх байдлаар нь дараах байдлаар авч үзлээ.

Оцог хадны гянтболдын ордыг ашиглах төслийг хэрэгжүүлснээр байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл нь уулын ажлын технологийн шалтгаанаар үүсэх бөгөөд Байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд тэдгээрийг дараах байдлаар авч үзсэн байна.

3.1 Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Агаарын бохирдол (уурхайн малталт, овоолгууд, тээврийн зам болон хөрс хуулалт, хүдэр ачих буулгах зэрэг технологи ажиллагаанаас тоос дэгдэнэ).

- Тэсэлгээний үед тоосжилт үүснэ
- Машин техникийн ажиллагаанаас хортой хий, утаа тортог гарна.
- Түр суурьшлын бүсэд хог хаягдал, шатах тослох материалын үнэр хүрээлэн буй орчинд тархана.

“Оцог хад” –ны гянтболдын уурхайн үйл ажиллагааны явцад агаар мандалд хаях бохирдуулагч эх үүсвэрүүдэд цэгэн болон талбайн, түр зуурын эх үүсвэрүүд багтана. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийг дараах байдлаар хуваан үзэж болно. Үүнд:

- Нүүрс түлж, дулаан гаргах бохирдлын цэгэн эх үүсвэр;
- Материал дамжуулах, тээвэрлэх хэсгүүд дэх бохирдлын цэгэн эх үүсвэрүүд;
- Агааржуулалтын амнуудын цэгэн эх үүсвэрүүд;
- Тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагчид;
- Ил талбай, замууд, түр болон байнга байх хаягдлын овоолгуудын талбайн эх үүсвэрүүд зэрэг болно.

Далд уурхайн үйл ажиллагааны явцад хүдэр болон чулуулгийг гадаргууд ил гаргах, дотоод тээвэр, уурхайн дотоод зам тавих, засах зэрэг газар шорооны ажил явагдана. Боловсруулах үйлдвэр, хаягдлын байгууламж байгуулах талбайг бэлдэх болон бусад дэд бүтцийн байгууламжуудыг барих үед хийх хөрс хуулалт, өнгөн хөрсийг зайлуулах үйл ажиллагааны үед хучилтын материалын хуурай шинж чанараас шалтгаалан их хэмжээний тоосжилт бий болно.

3.2 Газрын гадарга, хэвлий түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уулын ажил явуулах талбайн хэмжээгээр газрын эвдрэл үүсэж, газар эзэмших боломжийг хязгаарлана. Төслийн ашиглалтын нийт хугацаанд босоо болон хэвтээ амаар газрын хэвлийд далд уурхайн аргаар 53-200 м гүн нэвтэрч 93870 тн хурдас чулуулгийг ухаж эвдрэл үүсгэнэ. Үүнээс 2025 онд 150 хоног ажиллаж 39,766.0 тн уулын цулыг ашиглалтаар олборлохоор төлөвлөсөн. Ашиглалтын үеийн хайгуулын ажлаар уулын далд нэвтрэлт /штольн, штрек, босоо, налуу малталт/ -ийг 2x2.2 м –ийн хөндлөн огтлолоор 1000 т.м нэвтрэлтийн ажил буюу 11,440.0 тн уулын цул нурааж хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Төслөөс газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь дундаас их түвшинд гэж үнэлэгдсэн. /БОННУ хуудас 66/

3.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уурхайн усны хэрэгцээг хангахад шаардлагатай усны ундарга нь 1.58 л/сек байна. Ордоос 14 км-ийн зайд байх Хөндийн гол, 7 км –ийн зайд байх Нүцгэний голоос технологийн болон унд ахуйн усаа 15 тн багтаамжтай ёомкс бүхий авто машинаар зөөврөөр авч хэрэглэнэ. Уурхайн ашиглалтын үед цэвэр усны үндсэн хэрэглэгчид нь хүдэр баяжуулах үйлдвэр, далд уурхай, ажилчдын хотхон байна. Уурхайд эхний жил хоногт 59.62 м³, 2-3 дахь жилд 105.32-124.2 м³, нийт ашиглалтын жилд хоногт 288.96 м³ усыг зөөврөөр хангахаар төлөвлөсөн байна.

Ордын талбай нь дээд тал нь 2894 м үнэмлэхүй өндөрт байрлах ба хайгуулын хэвтээ малталт /штольн-I/ -ыг үүнээс доош 100 м- ийн доор буюу 2795м үнэмлэхүй өндрийн түвшинд хэвтээ чиглэлд 433 тууш.м штольн, 2755 м үнэмлэхүй өндрийн түвшинд хэвтээ малталт /штольн-II/ -ыг 380 т.м штольн, 2695 м үнэмлэхүй өндрийн түвшинд хэвтээ малталт /штольн-III/ -ыг 195 т.м штольныг тус тус нэвтэрсэн боловч энэхүү далд малталтанд ямар нэгэн ус байх шинж тэмдэг харагдаагүй байна.

Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөг БОННУ-нд 5 үзүүлэлтээр авч үзэн 60 хувь нь нөлөөгүйгээс бага зэргийн, 40.0 хувь нь дунд зэргийн сөрөг нөлөө үзүүлэхээр байна гэж дүгнэсэн. Учир нь тус уурхай усны хэрэглээгээ зөөврөөр хангах тул усны хэрэглээ бага байна.

3.4 Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Хүдрийн овоолго үүсгэх үйл ажиллагаанаас ургамлан нөмрөг дарагдах, тоосжилтод өртөх зэрэг гол сөрөг нөлөөллүүд үзүүлнэ. Төслийн үйл ажиллагааны улмаас 1.5 га талбайн ургамлан нөмрөг шууд нөлөөлөлд өртөнө.

Оцог хадны гянтболдын уурхайн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг дараах байдлаар үнэлсэн.

1. Ил уурхайн үйл ажиллагааны явцад хөрсний гадаад овоолго байршуулах үеийн хөрс хуулалтаар 0.52 га, бусад барилга байгууламж барих зам талбай засах үед 0.68 га, гар аргаар уурхайлалтад өртсөн 0.25 га нийт 1.5 га талбайн ургамлан нөмрөг шууд устана. Уурхайлалт болон бусад дагалдах үйл ажиллагаанаас ургамлан нөмрөг устаж, доройтох эрсдэлтэй бөгөөд цаашид ургамлын бүлгэмдэлд урт хугацааны нөлөөллийг бий болгоно.

2. Уурхайн барилга байгууламж барих болон хөрс ачих, буулгах, мөн тээвэрлэх үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим буурах, энэ нь чийгийн дутагдалтай, хур тунадасны хэмжээнээс ууршилт давамгайлах бүс нутаг учир уурхайн үйл ажиллагаа, тээврийн хөдөлгөөн, ачилт, буулгалт, хөрс хуулалт зэргээс үүдэж тоос агаарт дэгдэн, улмаар газрын гадаргад бууж, орчны тоосжилтыг үүсгэнэ.

- Хөрс хуулалт, дотоод гадаад тээвэрлэлтээс үүдэлтэй ургамлан нөмрөг биет хэмжээгээр сүйтгэгдэнэ.
- Бэлчээрийн ашиглалтад сөргөөр нөлөөлж идэмжит ургамал түрэгдэнэ.
- Түр суурьшил, техник парклат бүхий газруудад ургамлан нөмрөг талхлагдана.
- Орчны бохирдол, доройтлын улмаас ургамлын ургах орчин хязгаарлагдмал хүрээнд муудна.

Төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх 4 нөлөөлөл байгаагийн 25.0 хувь нь бага, 75.0 хувь нь унд эрчимтэй байна. Ургамалд үзүүлэх сөрөг нөлөө нь тодорхой зүйл ургамал устаж гүй болох хүртэл сүйрлийн түвшний сөрөг нөлөө үзүүлэхгүй. Тиймээс ургамлан нөмрөгийг нөхөн сэргээж, зориудын аргаар ургамалжуулах шаардлагатай бөгөөд энэ нь аяндаа цэгцрэх үйл явцыг ихээхэн хэмжээгээр хурдасгана.

4 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах байлаа. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянахаар төлөвлөн ажиллаж байна.



Фото 5. Төслийн талбайн ерөнхий төрх

5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг БОННУ – нд тусгагдсанаар дараах үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Агаарын чанар	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор замыг тогтмол услаж байх	Зам талбай	төгрөг	30,000	15	450,000	Тогтмол	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
		Автотээврийн улсын үзлэг оношлогоог хийлгэж хүнд даацын тээврийн хэрэгслүүдэд хөдөлгүүрийн утааны тортогжилтын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг хийх, эсхүл ашиглалтаас гаргах	Хүнд даацын тээврийн хэрэгсэл	төгрөг				Тогтмол	
		Ил задгай хог хаягдлыг шатаахыг хориглох, ахуйн хог хаягдал болон бохирын цооногт ариутгал халваргүйжүүлэлтийг хийх	Уурхайн нутаг дэвсгэрт	төгрөг	100,000	4	400,000	Тогтмол	

2	Байгаль орчинд	Байгаль орорчны аудит хийлгэх	Уурхайн үйл ажилгаанд	төгрөг	Өөрийн зардалаар	2 жилд 1 удаа			Холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангах
3	Хөрсөн бүрхэвч	Байгаль орчинд ээлтэй ажилчдын био 00-н асуудлыг шийдвэрлэх	Уурхайн нутаг дэвсгэрт		Өөрийн зардалаар			2026 онд	Холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангах
4.	Хөрсөн бүрхэвч	Шимт хөрсний овоолгыг технологийн дагуу хадгалах, шимт чанарыг сайжруулах	Овоолго	төгрөг	500,000	1	500,000	Тогтмол	Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
		Хөрсөн дээр тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсэгт элс асган саармагжуулан, бохирдсон хэсгийг хаягдал руу ачуулах	Хөрсөн бүрхэвч	төгрөг	300,000	1	300,000	Тогтмол	
	Нийт						1,650,000		

6 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт /уурхайн бүс/	Ухсан газрыг шимт хөрсөөр дүүргэх, ашиглагдахгүй байгаа зам талбайг янзлах	Төгрөг	0,8 га	1,300,000	1,300,000	2026 онд	
	Нийт					1,300,000		

7 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь далдаар олборлолт явагдах тул тухайн бүс нутгийг төлөөлж чадахуйц газар нутгийг сонгон дүйцүүлэн хамгаалах ажлыг орон нутагтай хамтран хэрэгжүүлнэ. Тухайн орон нутагт хууль бус ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд өртөж эвдрэлд орсон талбайд орон нутгийн саналаар Алтай сум Ямаан усны орлого гэдэг газарт техникийн нөхөн сэргээлтийг 0,6 га талбайд хийх.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга, хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8

1.	Төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах, багасгах арга хэмжээ авсны дараа үлдэж байгаа нөлөөллийг арилгах	Хууль бус ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд өртөж эвдрэлд орсон талбайд	Төслийн талбай /Алтай сумын Бодонч багийн нутаг дэвсгэрт- Ямаан усны орлого -т	0,6 га	3,300,000	3,300,000	2026 онд	
		Сумын нэгдсэн хогийн цэгийг лахдфилийн аргаар булж тэгшлэх	Хог хаягдалыг түрж тэгшлэх		2,100,000	2,100,000	2026 онд	
2	Алтай сумын төвд мод бут тарих	Алтай сумын төвд мод бут тарих	Алтай сумын босоо тэнхлэгийн авто зам дагуу	1500 ш	7,000,000	7,000,000	2026 онд	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд
3	Үенч сумын нутаг дэвсгэрт	Үенч сумын нутаг дэвсгэрт	Нарийн гол баг Нүцгэний гол дагуу /1 га талбайд/	500 ш	2,500,000	2,500,000	2026 онд	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд
4.	Сурталчилгааны самбар байрлуулах	2-3 ш 1,20*3 м хайрцаатай 2талдаа хэвлэлтэй байгаль орчны сурталчилгааны самбар	Булган сумаас Ховд хот хүртлэх босоо тэнхлэгийн зам дагуу	3 ш	1,500,000	4,500,000	2026 онд	

5	Гадаргын усны мониторинг судалгааг хийх ажлыг хамтран зохион байгуулсан байх	Сав газрын хэмжээнд хамаарах гадаргын уст цэгүүдэд судалгаа мониторинг хийж үр дүнг тайлагнах		Алтай, Үенч сумдад	3,500,000	3,500,000	2026 онд
6	Сав газрын талуудын зөвлөлийн хурлыг зохион байгуулахад хамтын оролцоог хангах	Зохион байгуулалтад хамтран оролцож шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх		Булган сум	1,000,000	1,000,000	2026 онд
Нийт						23,900,000	

8 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн талбайд өмнө нь 2 айлын өвөлжөө байсан бөгөөд 2018 онд тус 2 өвөлжөөг нүүлгэснээр одоо тухайн төслийн талбайд ямар нэгэн нүүлгэн шилжүүлэх шаардлага гарахгүй тул нүүлгэн шилжүүлэлт ба нөхөн олговор олгох арга хэмжээ авагдахгүй юм.

9 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ховд аймгийн Алтай сумын нутагт орших Богоч хэмээх ашигт малтмалын хайгуулын талбайд түүх, археологийн дурсгалуудыг археологийн судалгааны орчин үеийн арга зүйн дагуу нарийвчилсан хайгуулыг гүйцэтгэсэн боловч ямар нэгэн түүх, археологийн дурсгал илэрч мэдэгдээгүй байна.

Уурхайн ашиглалтын талбай нь Алтайн нурууны уулархаг хэсгээс бүрдсэн, хойт талаараа их уулстай тэдгээр уулсын дамнан байрлах учир хүмүүсийн оршуулгын болоод ахуйн үйл ажиллагааны ул мөр харьцангуй бага хадгалагджээ. Тус компани одоогоор тус хайгуулын талбайд ашигт

малтмалын хайгуулын далд малталтын хэвтээ амны 2.0x2.2 м хөндлөн огтлолтой уулын далд малталт /штолын/ нэвтэрсэн байна. Түүнийг түүх, археологийн дурсгал дайрагдсан өртөгдсөн эсэхэд нарийвчилсан шалгалт хийсэн бөгөөд энэхүү уулын далд малталтанд ямарваа нэгэн түүх,

археологийн дурсгал өртөгдөөгүй болно. Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүх соёлын дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой үүргээ биелүүлэн ажиллана.

10 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төсөл хэрэгжих хугацаанд өрөмдлөг-тэсэлгээний ажилд жилд энгийн найрлагат “эмульс” тэсрэх бодис ашиглана. Энэ тэсрэх бодисын найрлагад ордог химийн хортой ба аюултай бодисуудын эрсдэлийн үнэлээг БОННУ хийсэн. Уурхайн тэсрэх бодис, шатах тослох материалаас өөр химийн аюултай бодис хэрэглэхгүй.

Тиймээс ажилчидад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана.

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга, хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Түймэр, гал түймэр гарах	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл бэлдэх	Ажлын байр	18	30,000	540,000	2026 онд	
2.	Ажилчдын аюулгүй	Болзошгүй аваар ослын үед яаралтай	Нийт ажилчид	2	230,000	460,000	Тогтмол	

	байдлыг хангах	хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах эм						
		эмнэлгийн зардал						
	Нийт					1,000,000		

11 ХОГ, ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын анхан шатанд нь ангилан ялгаж, хаях ажлыг хэвшүүлж, дахин ашиглах хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлнэ. Хог хаягдлыг зохистойгоор хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт хийж, ажлын байрны шалгалт тогтмол явуулна. Мөн аюултай хог хаягдалын бүртгэлийг тогтмол хийж үйлдвэрлэлийн жилийн төгсгөлт тайлагнан байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулна.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримлах эрх зүйн баримт бичиг
		1	2	3	4	5	6	7	8
1.	Ахуйн	Холбогдох байгууллагатай шинэчлэгдсэн хууль, журмын дагуу гэрээ		төгрөг		3	Өөрсдийн унаагаар тээвэрлэнэ	Жил бүр	“Хог хаягдлын тухай” хууль -

		байгуулан тээвэрлүүлэх							
2.	Үйлдвэрийн	Дугуй, төмөр зэрэг үйлдвэрийн хог хаягдлыг гэрээгээр тээвэрлүүлэх	Үйллвэрийн хог хаягдал	төгрөг		5	Өөрсдийн унаагаар тээвэрлэнэ	Жил бүр	
	Нийт						-		

12 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тус компани нь байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн эрсдлийг бууруулах талаар байнгын хяналт тавин ажиллахын зэрэгцээ байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулан түүний дагуу байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь байгаль орчны чиг үүргийг тодорхойлж байгаа бодлогын хэрэгжилтийн нэг хэсэг юм.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
Агаар	<p>Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос PM2.5, PM10 Тоосны уналт Бохирдлын цэгэн эх үүсвэр: SO₂, NO_x Тоосжилтын бохирдлын хэмжээ</p>	<p>- Уурхайн гадаад тээврийн замаас салхины доод талд - Уурхайн агааржуулалтын амны хэсгээс - Уурхайн ажилчдын кемпийн орчимд - Хаягдал чулуулгийн талбай орчимд талбайгаас салхины доод талд</p>	Жилд 2 удаа	2	300,000	600,000	Уурхайн дотоод зам талбайн тоосжилтын байдалд өдөр бүр нүдэн баримжаагаар ажиглалт явуулж бүртгэл хөтлөх, зам талбайн тоос дарах ажилд хяналт тавих	<p>MNS 4048-88. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга. MNS 3384-82. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4585-2016. Агаар орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 12.055-91. Ажлын байрны агаар дахь тоосны хэмжээг тодорхойлох</p>

Хөрс	- Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбанат, хүнд металл (Cr, Pb, Ni, Zn) бактери	-Шимт хөрсний овоолгоос -Уурхайн овоолгоос -Шатах тослох материалын агуулах орчмоос -Ажилчдын тосгоноос	Жилд 2 удаа	2	150,0	300,00 0		Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох MNS 3310-91
Ус	- Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ. (рН, ЕС, TDS-ийн нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ гэх мэт) - Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ бактериологийн шинжилгээ. (рН, ЕС, TDS-ийн нийт шүлтлэг, хатуулагын хэмжээ гэх мэт)	-Ахуйн хэрэглээний усанд -Ус хуримтлуулах нуур -Голын усанд	Жилд 2 удаа	2	200,00 0	400,00 0		Усны чанарыг тодорхойлох MNS 4586:1998.
	Нийт					1,300,000		

13 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Талст молор” ХХК-ийн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго:

- o БОНБНУ-ний судалгаагаар урьдчилан гаргасан нөлөөллүүдийг хүлээн зөвшөөрсөн хэмжээнд байлгах
- o Уурхайн нөлөөлөлд өртөж болзошгүй болон хяналтын байршилд мониторинг хийх цэгүүдийг сонгож байгалийн өөрийн өөрчлөлт ба уурхайн нөлөөллөөс үүсэх өөрчлөлтийг харьцуулан судлах бололцоо олдохуйц мэдээлэл бүрдүүлэх
- o Байгаль орчны стандарт, хууль, эрх зүйн баримт бичгийн өөрийн фондтой болж, хэлтсүүдийг бодит мэдээллээр шуурхай хангаж байдлыг сайжруулна.
- o Мониторингийн ажлын үр дүнг байгаль орчны менежментийн үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх 2026 оны байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг ус, агаар, хөрс, гэх мэт судалгааны хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийхээр төлөвлөөд байна.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Сар	Сар	Сар		
	1	2	3	4	5	6	7
1.	71 хүнийг ажлын хувцсаар хангах	-				Ерөнхий захирал	Өөрсдийн зардлаар
2.	71 хүний хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах	-				Байгаль орчны асуудал хариуцагч	Өөрсдийн зардлаар
3.	Аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар тайлбарлаж таниулах, сургалт зохион байгуулах	-				Ерөнхий захирал	Өөрсдийн зардлаар
	Нийт	-					

14 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Талст молор” ХХК-ийн “Оцог хад” нэртэй гянтболдын үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийн үндсэн үйл ажиллагаа буюу ашигт малтмал ашиглах лицензтэй талбай нь Ховд аймгийн Алтай сумын нутагт байрладаг. Тиймээс энэхүү төслийн нөлөөлөлд өртөгчид мөн төсөлд оролцогч талууд нь сумын иргэд, малчид болох юм. 2026 онд сумтай холбоотой асуудлаар дараах хүснэгтэнд үзүүлснээр хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан, ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Харьяалагдах аймаг нийслэлийн Байгаль орчны газар	3-аас доошгүй хэвлэмэл болон цахим хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилтийн талаарх бүрэн тайлан	11-р сарын 1-ний дотор	100,000	Төсөл хэрэгжүүлэгч	
2.	БОМТ-н хэрэгжилтийг хянах ажлын хэсэг	Төслийн талбайд	БОМТ-н хэрэгжилтийг газар дээр нь хянуулж, үнэлэлт дүгнэлт авах	11-р сарын 30-ны дотор	900,000	Төсөл хэрэгжүүлэгч	
3.	Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага	Тайлангаа танилцуулж бичгээр санал авна	Тухайн оны БОМТ-ний хэрэгжилт танилцуулах, дараа жилийн БОМТ-г батлуулах	12-р сарын 30ны дотор	100,000	Төсөл хэрэгжүүлэгч	
4.	Баг /сум/ -ийн иргэдэд тайлагнах	Орон нутагт	БОМТ-ний хэрэгжилтийн талаарх бүрэн тайлан	11-р сарын 1ний дотор	100,000	Төсөл хэрэгжүүлэгч	
	Нийт				1,200,000		

Ховд аймгийн Алтай сумын нутагт байрлах “Оцог хад” гянтболдын уурхайн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 30 сая 350 мянга 000 төгрөг төлөвлөж байна.

15 ХАВСРАЛТ

Хууль зүйн сайдын 2016. оны
... А/204... дугаар тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000137208

2013.11.26 / Бүртгэсэн он, сар, өдөр /

9011444150 / Улсын бүртгэлийн дугаар /

5774047 / Регистрийн дугаар /

Талстмолор Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм / Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр 01 2013.11.21
/ шийдвэрийн нэр / / дугаар / / он, сар, өдөр /

7210 / код / Геологийн суурь судалгаа хийх
/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

4530 / код / Автомашины дугуйны худалдаа, засвар үйлчилгээ
/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй 2 1 020,0
/ хугацаа / / гишүүдийн тоо / / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянзүрх, 18-р хороо, 13 хороолол, 171 б, 13 тоот, Утас1: 99079440, Утас2: 99132103, Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, улсын бүртгэлийн
ерөнхий газар Хуулийн этгээдийн
бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2017 он 1 сар 16 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэлэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Батмэнд овогтой Мөнхтөр-а Захирал-р томилсныг бүртгэв.	2017.01.16	О.Шижиртуяа
2	Дахин гэрчилгээ олгов.	2017.01.16	О.Шижиртуяа
1	0899 Ашигт малтмал ашиглах /2017.06.28-2047.09.28/ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2018.03.29	Б.Гэрэлзүл



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар **MV-020930**

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

_____ **Ховд** _____ аймаг /хот/-ийн

_____ **Алтай** _____ сум /дүүрэг/-ын

_____ **Богоч** _____ нэртэй газарт орших

_____ **407.99** _____ гектар талбай бүхий уурхайн талбайд

хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн _____ **9011444150** _____ тоот гэрчилгээтэй

_____ **“Талстмолор” ХХК** _____ -д

энэхүү тусгай зөвшөөрлийг _____ **2047.09.28** _____ дуустал

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Д.МӨНХТАМИР

2017 оны 9 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

0000142



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ**

MV-020930

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
008-FE	<ul style="list-style-type: none"> Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 7 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2023.09.28 – 2024.09.28 хүртэл 	<div style="border: 1px solid black; padding: 5px; display: inline-block;"> <p>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ07043</p> </div> 2023.09.26
011-FE	<ul style="list-style-type: none"> Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 8 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2024.09.28 – 2025.09.28 хүртэл 	<div style="border: 1px solid black; padding: 5px; display: inline-block;"> <p>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ07043</p> </div> 2024.09.19



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
2 ДУГААР ХАВСРАЛТ**

MV-020930

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				#	Уртраг	Өргөрөг
001-NM	<ul style="list-style-type: none"> Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2017.09.28 	407.99 Га	0 Га	1	92° 18' 38.24"	46° 18' 35.23"
				2	92° 16' 25.15"	46° 18' 35.23"
				3	92° 16' 37.17"	46° 18' 57.37"
				4	92° 16' 53.34"	46° 19' 27.17"
				5	92° 18' 38.24"	46° 18' 27.17"
				2017-09-28		Д.Мягмарсүрэн



ҮНДСЭНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 4/120

Улаанбаатар хот

Нөөц бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн ХХ-16-08 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Богоч” нэртэй XV-019692 тоот ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамаарах Ховд аймгийн Алтай сумын нутагт орших “Оцог хад” гянтболдын үндсэн ордод 2018-2020 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн тодотгол тооцооны тайлан (Ордын нөөц 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар) дах хэт өндөр агуулга хязгаарласан хувилбараар ордын геологийн нөөц бодитой (В) зэрэглэлээр 150,827.04 тн хүдэрт 0.40 % дундаж агуулгатай, 608.05 тн гянтболд, боломжтой (С) зэрэглэлээр 159,184.49 тн хүдэрт 0.47%-ийн дундаж агуулгатай, 747.76 тн гянтболд, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 310,011.53 тн хүдэрт 0.44%-ийн дундаж агуулгатай, 1,355.81 тн гянтболдын нөөцийг хүлээн авч бүртгэсүгэй.

2. Хүлээн авсан геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Гео-мэдээллийн төв (Ц.Минжинсор)-д даалгасугай.

3. Дээрх нөөцийг хүлээн авсантай холбогдуулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны ХХ-13-17 дугаар дүгнэлтэд үндэслэсэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн Н/83 тоот тушаалаар хүлээн авсан бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 105.11 мян.тн хүдэрт дэх 459.91 тн гянтболдын нөөцөөс олборлоод үлдсэн бодитой (В) зэрэглэлээр 5.07 мян.тн хүдэрт 1.31 тн гянтболд, боломжтой (С) зэрэглэлээр 40.71 мян.тн хүдэрт 221.84 тн гянтболд, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 45.78 мян.тн хүдэрт 223.15 тн гянтболдын нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн бүртгэлээс хасахыг Гео-мэдээллийн төв (Ц.Минжинсор)-д даалгасугай.

4. “Богоч” нэртэй XV-019692 тоот ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамаарах Ховд аймгийн Алтай сумын нутагт орших “Оцог хад” гянтболдын үндсэн ордод 2018-2020 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн тодотгол тооцооны тайланг бичвэр дискийн хамт Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдааны дүгнэлт, түүний дагуу гаргасан Үндэсний Геологийн Албаны даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг “Талст молор” ХХК (Б.Мөнхтөр)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.МӨНХБИЛЭГ

182501 00678



АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2025 оны 11 сарын 06 өдөр

Дугаар ХХ-16-06

Улаанбаатар хот

Ховд аймгийн Алтай сумын нутагт орших “Оцог хад” гянтболдын үндсэн ордод 2018-2020 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн тодотгол тайланг хэлэлцсэн тухай

Ховд аймгийн Алтай сумын нутагт орших “Оцог хад” гянтболдын үндсэн ордод 2018-2020 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр Монгол Улсын мэргэшсэн геологич Э.Доржтотов, геологич Л.Цэдэндулам нарын боловсруулсан тайлан, уг тайлан болон ордын нөөцийн тооцоонд Монгол Улсын мэргэшсэн геологич Н.Цэнгэлбаярын хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна. Үүнд:

1. Ховд аймгийн Алтай сумын нутагт орших 5075.41 га талбай бүхий “Богоч” нэртэй XV-019692 дугаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг АМГ-ын КХ-ийн даргын 2015 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 886 тоот шийдвэрээр “Литолог” ХХК-д олгосон бөгөөд улмаар АМГТГ-ын КХ-ийн даргын 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 132 тоот шийдвэрээр “Талст молор” ХХК-д шилжүүлснийг бүртгэсэн байна. “Талст молор” ХХК 2016 онд хайгуулын ажил гүйцэтгэж нөөцийг бүртгүүлснээр 407.99 га талбай бүхий Богоч нэртэй MV-020930 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын кадастрын хэлтсийн даргын 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 570 тоот шийдвэрээр олгосон байна.

2019 онд тус аж ахуйн нэгжийн хувьцаа эзэмшигч Б.Мөнхтөр, Д.Цогтэрэл нарын хооронд маргаан гарсан бөгөөд уг маргаан нь уурхайн талбайгаас олборлосон их хэмжээний гянтболдын баяжмалыг тухайн уурхайд туслан гүйцэтгэгчээр ажиллаж байсан БНХАУ-н иргэдтэй Д.Цогтэрэл хуйвалдан авч явсан асуудлаас үүдсэн байдаг.

Ингээд Д.Цогтэрэл нь 2020 оны 02 сард Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд “Талст молор” ХХК-ийн 95 хувийн хувьцааг Б.Мөнхтөрд шилжүүлж бүртгэсэн улсын бүртгэлийг хүчингүй болгуулах шаардлага бүхий нэхэмжлэл гаргаж 3 жилийн хугацаанд шүүхэд хянан хэлэлцэгдэж, олон удаагийн шүүх хурал болсон бөгөөд хамгийн сүүлд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн №764 тоот шийдвэрээр Д.Цогтэрэлийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Баянзүрх дүүргийн Иргэний анхан шатны шүүхийн 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн №03973 тоот шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж “Талст молор” ХХК-ийн 95 хувийн хувьцааг Б.Мөнхтөрд шилжүүлэхийг хариуцагч Д.Цогтэрэлд даалгаж шийдвэрлэсэн. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн №02025, Улсын дээд

шүүхийн Хяналтын Шатны Иргэний Шүүх Хуралдааны 2024 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн №00021 тоот тогтоолоор анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр нь үлдээж шийдвэрлэсэн. Улсын бүртгэлийн байгууллага 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Б.Мөнхтөрийг “Талст молор” ХХК-ийн эцсийн өмчлөгчөөр бүртгэсэн бөгөөд Б.Мөнхтөр компанийн тухай хуулийн 61.7 дахь хэсэгт заасны дагуу компанийн дүрэмд өөрчлөлт оруулж 95 хувийн хувьцаа эзэмшигч, захирал Б.Мөнхтөр болгон өөрчилж улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлсэн бөгөөд Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас дээрх дүрмийн өөрчлөлтийг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр улсын бүртгэлд бүртгэж Б.Мөнхтөр, Д.Цогтэрэл нарын “Талст молор” ХХК -ийн хувьцаа эзэмшлийн талаарх шүүхийн маргаан албан ёсоор дуусаж, одоо тус компанийн захирал 95 хувийн хувьцаа эзэмшигч Б.Мөнхтөр компанийг удирдаж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

“Оцог хад” гянтболдын орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 1450 км, Ховд аймгийн төв Ховд хотоос урагш 295 км, Үенч сумын төвөөс зүүн хойш 35 км, Алтай сумын төвөөс баруун хойш 58 км-т, Ярант боомтоос зүүн тийш 195 км-т байрлана.

2. “Талст молор” ХХК нь тус талбайд 2018-2020 онд хайгуулын ажил гүйцэтгэж, ордын нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр тооцоолж, хайгуулын ажилд нийт 198,466.37 мянган төгрөг зарцуулсан байна.

3. 1951 онд В.М.Синицын, В.А.Амантовын хамт Алтайн говийг хамарсан томоохон нутагт судалгаа явуулж тектоникийн 5 бүс, түүний дотор Бодончийн талбайг багтаасан Баруунхуурайн бүсийг анх ялгажээ.

1966 онд П.С.Матросов зураглалын талбайн хэмжээнд Баруун хуурайн ба Байтагийн бүсүүдийг ялгаж, түрүү дунд ба хожуу вариссын хөгжлийн үе шатыг ангилжээ.

1967, 1969 онд Монгол-Зөвлөлтийн геологийн ба палеонтологийн хамтарсан экспедицүүд байгуулагдсан явдал манай орны геологийн судалгаанд таатай нөлөө үзүүлсэн юм. Тухайлбал: Алтайн нуруунд тархсан палеозойн хурдасны давхарга зүй /Борбургас, Үенч, Сагсай г.м/ тэдгээрийг төлөөлөх амьтан, ургамлын олдворууд тогтоогдсон.

1996-1998 онд Ховд аймгийн Үенч, Алтай, Мөст сумдын нутгийг хамарсан “Үенчийн талбайн 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын тайлан”. Зохиогч: Б.Дашцэрэн, Д.Аюуш.

1999 онд Ховд, Говь-Алтай, Баян-өлгий, Увс аймгийн ихэнх нутгийг хамарсан Монгол Алтайн талбайн үнэт, өнгөт, ховор төмөрлөгийн 1:200 000-ны хураангуйлалтай прогноз-металлогений зураг зохиох сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, зохиогчид: С.Дандар, Ш.Энхбаатар, Г.Дэжидмаа, Е.Энхбат бусад, /ф5306/ зохиогдсон байна.

2013 онд УГЗ-200 хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн УГЗ-200-Б-IV Судалгааны геологи, ашигт малтмалын иж бүрдэл зохиогдсон байдаг. Зохиогч: Б.Доржсүрэн нар/ф7275-3/.

2016 онд Оцог хад ордын анхны хайгуулын ажлын үр дүнгийн тайланг геологич Д.Цогтэрэл, Б.Амгаланбаяр, Бэ.Баянжаргал нар боловсруулж, ордын вольфрамын гуравч ислийн нөөцийг бодиттой болон боломжтой зэргээр хүдрээр 105116.76 тн, металлаар 456.91 тн нөөц, илрүүлсэн (P₁) болон баримжаалсан (P₂)

баялгийг хүдрээр 140168.94 тн, металлаар 407.93 тн гэж МУ-ын Эрдэс баялгийн санд бүртгүүлсэн байна.

4. Талст Молор” ХХК 2018-2020 онуудад 2701.6 м³ далд малталтын ажлыг гүйцэтгэжээ. 2016 онд баяжигдах шинж чанарын судалгаа, палеонтологийн судалгааны ажил, археологийн судалгааны ажлыг гүйцэтгүүлсэн байна. 2020 онд нэмэлт хайгуулын ажлын хүрээнд гадаргуугийн сорьцлолтын цэг болон далд уурхайн хайгуулын штрек нэвтрэлтүүдийн ажлыг Талст молор ХХК-ний маркшейдер инженер болон Эволюшн сүрвэй ХХК-ний маркшейдер инженерүүд гүйцэтгэсэн байна.

5. Өмнөх судлаачдын материалаар “Оцог хад”-ны орд байрлаж буй шток хэлбэрийн жижиг интрузив биетийн насыг судалгааны талбайгаас баруун хойш чиглэлд шууд үргэлжлэл дээр, структур-тектоникийн нэг бүсэд 15 км зайд байрлах Улаан эргийн массивийн үнэмлэхүй насны үндэслэлээр /насны хязгаар нь 240.8-+1.2 сая жил/ дунд триас гэж үзжээ.

Уг бүрдлийн гүний чулуулаг нь микроскопын тодорхойлолтоор жижиг-дунд ширхэгтэй грейзенжсэн мусковитот гранит гэж тодорхойлогдсон байна. Орд нь Оцог хад хэмээх 2927 м тоот өндөрлөгийн орчимд, дунд ширхэгтэй, саарал өнгийн грейзенжсэн гранитын шток маягийн жижиг интрузив дотор байрлах зүүн хойшоо 24⁰-40⁰ чигтэй, нэг чигийн жижиг хагарал, суларсан бүсийг дагасан кварц-вольфрамитын судлын төрлийн биет юм. Кварц-вольфрамитын судлууд нь үндсэндээ зүүн хойш чиглэлтэй, суналын дагуудаа 40-230 м урт үргэлжилсэн, зүүн урагшаа 65⁰-75⁰-аар босоо шахуу уналтай, 0.2-1.9 м хүртэл зузаантай, хоорондоо 90-120 м зайтай, нэг чиглэлд сунаж тогтоон 4 тооны зэрэгцээ судлуудаас бүрдэнэ.

Судлууд нь Оцог хадны орчимд гадаргуугийн өндөрлөг хэсгүүдээр ил гарш байдлаар харагдах боловч суналын дагуудаа баруун урагш-зүүн хойш чиглэлд гадаргын нам дор хэсгүүдэд элюваль гаралтай гранитын валун, глыб, түүнчлэн нуранги асга хад болон сэвсгэр хурдсаар хучигдсан байдаг.

Уг бүрдлийн чулуулгийг зүсэж тогтсон кварц-вольфрамитын судлуудын хил заагт зэсийн хоёрдогч исэл болох малахит, азурит, төмрийн усан исэл болох лимонит, гётит, карбонаитит, марганцын өнгөр түрхэц нэлээд ажиглагдана (фото №11). Грейзенжсэн мусковитот гранит, кварцын судлын хил зааг дагуу гадаргууд болон уулын далд малталтаар грейзенжих хувирал ~ 0.5-10 см зузаантайгаар хүдрийн биетийн дагуу тогтворгүй илэрдэг бөгөөд кварцын судлуудад 0.5-3 см хүртэлх хэмжээтэй вольфрамитын шигтгээлэг хүдэр жигд бус тархалттайгаар, сульфидээс пирит, халькопирит 2x4 см хүртэлх хэмжээгээр ховроор агуулагдсан байна. Уулын далд малталт буюу 1-р штольд кварц вольфрамитын 1, 4-р хүдрийн биетээс гадна 0.5x2 см хүртэлх өргөнтэй кварцын нарийн судал, судланцарууд хүдрийн биеттэй параллель байдлаар тохиолдоно.

1-р хүдрийн биет нь суналын дагуу 571 м, уналын дагуу 135 м хүртэл үргэлжилнэ, уналын грдаус нь дунджаар 76⁰, биетийн дундаж зузаан 0.84м, дундаж агуулга нь 0.51% байна.

3-р хүдрийн биет нь суналын дагуу 232 м, уналын дагуу 116 м хүртэл үргэлжилнэ, уналын грдаус нь дунджаар 75⁰, биетийн дундаж зузаан 0.7м, дундаж агуулга нь 0.56% байна.

4-р хүдрийн биет нь суналын дагуу 678 м, уналын дагуу 96 м хүртэл үргэлжилнэ, уналын грдаус нь дунджаар 75⁰, биетийн дундаж зузаан 0.82м, дундаж агуулга нь 0.56% байна.

9. Ордын талбай нь Ховд аймгийн Алтай, Үенч сумдын зааг дээр Монгол Алтай нурууны баруун урд талын салбар уулсын дунд Оцог хад хэмээх 2927 м тоот өндөрлөгийн орчимд байрладаг. Ордын талбайгаас зүүн тийш 30 км-т Бодончийн гол, баруун тийш 13 км-т Үенчийн гол, түүний цутгал болох Нүцгэний гол зэрэг байнгын урсгалтай гол горхи байх ба ордын талбайн орчимд байнгын урсгалтай усан сүлжээ байхгүй. Өндөр уулархаг газар учир хур борооны үед түр зуурын урсгалаар хүчтэй үерлэж уруйн ус буух нөхцөлтэй юм. Ордод хамгийн ойр зайд байрлах уст цэг нь зүүн тийш 11 км-т, Бодончийн голын цутгал болох Хөндийн салааны дунд хэсэгт Ар булагийн аманд хур тунадас элбэгтэй жил байнгын урсгалтай жижиг горхи байдаг ба энд гүний худаг өрөмдөж гаргасан байдаг бөгөөд энэ нь зөөврийн устай жижиг баяжуулах үйлдвэрийн хэрэгцээг бүрэн хангах боломжтой байна. Хур тунадас багатай жил унд ахуй болон бусад үйлдвэрлэлийн усыг Бодончийн голоос зөөвөрлөн хэрэглэх боломжтой юм. Ордын талбай нь дээд тал нь 2894 м үнэмлэхүй өндөрт байрлах ба хайгуулын хэвтээ малталтыг үүнээс доош 100 м-ийн доор буюу 2795 м үнэмлэхүй өндрийн түвшинд хэвтээ чиглэлд 226 тууш.м штольн нэвтэрсэн боловч энэхүү далд малталтад ямар нэгэн ус байх шинж тэмдэг байгаагүй болно.

10. Оцог хад гянтболдын ордыг далд уурхайн аргаар ашиглаж, ашиглалтын хугацаанд хаягдал бохирдол тооцооноор 236.37 мян.тн хүдэр олборлон баяжуулж 904.2 тн баяжмал олборлон борлуулж 52.39 тэрбум төгрөгийн орлого олж, үйлдвэрлэлийн зардалд 32.42 тэрбум зарцуулж татварын дараах байдлаар 14.08 тэрбум төгрөгийн орлого олно. Цэвэр ашгийн түвшин 26.89%, NPV /10%/ 8,164.5 сая.төг, өгөөжийн норм /IRR/ 76.77%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 0.1 жил байхаар урьдчилсан тооцоо гарсан байна.


11. Цаашид байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон ордыг ашиглах ТЭЗҮ-ийг эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэх, холбогдох хууль тогтоомж, ялангуяа “Ашигт малтмалын тухай” хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.3 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Үндэсний геологийн албаны даргад уламжлахаар шийдвэрлэв. Үүнд:

Нэг. Ховд аймгийн Алтай сумын нутаг орших Оцог хад гянтболдын үндсэн ордод 2018-2020 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн тодотгол тайлан” (Ордын нөөц 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар) дахь хэт өндөр агуулга хязгаарласан хувилбараар бодиттой (В) зэрэглэлээр 150,827.04 тн хүдэрт 0.40 %-ийн дундаж агуулгатай, 608.05 тн гянтболд, боломжтой (С) зэрэглэлээр 159,184.49 тн хүдэрт 0.47 %-ийн дундаж агуулгатай, 747.76 тн гянтболд, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 310,011.53 тн хүдэрт 0.44%-ийн дундаж агуулгатай, 1355.81 тн гянтболдын нөөцийг энэхүү дүгнэлтийн хавсралт хүснэгт №1-ийн дагуу хүлээн авах.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан гянтболдын нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг УГА-ны Гео-мэдээллийн төв (Ц.Минжинсор)-д зөвшөөрөх.

Гурав. Дээрх нөөцийг хүлээн авсантай холбогдуулан АМГТГ-ын даргын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн Н/63 тоот тушаалаар хүлээн авсан бодитой



болон боломжтой (B+C) зэрэглэлээр 105,116.76 мян.тн хүдэрт дэх 459.91 тонн гянтболдын нөөцөөс олборлоод үлдсэн бодитой (B) зэрэглэлээр 5.07 мян.тн хүдэрт 1.31 тн гянтболд, боломжтой (C) зэрэглэлээр 40.71 мян.тн хүдэрт 221.84 тн гянтболд, бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 45.78 мян.тн хүдэрт 223.15 тн гянтболдын нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлээс хасаж нөөцийн хөдөлгөөн хийхийг УГА-ны Гео-мэдээллийн төв (Ц.Минжинсор)-д зөвшөөрөх.

Дөрөв.Энэхүү дүгнэлтийн 11 дүгээр заалтыг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Талст молор” ХХК-ний захирал (Б.Мөнхтөр)-д анхааруулах.


Тав. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан УГА-ны даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг “Талст молор” ХХК-ний захирал (Б.Мөнхтөр)-д даалгах.

Зургаа. “Ховд аймгийн Алтай сумын нутагт орших Оцог хад гянтболдын үндсэн ордод 2018-2020 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн тодотгол тайлан”-ийн боловсруулалтыг Монгол Улсын мэргэшсэн геологич Э.Доржготов, геологич Б.Амгаланбаяр, инженер Ж.Мөнхсайхан нар, байрзүйн зураглал, далд уурхайн нэвтрэлт хайгуулын малталтын ажил, маркшейдерийн хэмжилтийн ажлыг “Эволюшн сүрвэй” ХХК, “Талст молор” ХХК, лабораторийн шинжилгээний үр дүнг “Геологийн төв лаборатори” ХХК, палеонтологийн судалгааны ажлыг ШУТИС-ийн Геологи уул уурхайн сургуулийн Стратиграфи-Палеонтологийн төв, археологийн судалгааны ажлыг ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн, Хүмүүнлэгийн ухааны салбарын Археологийн судалгааны нэр бүхий судлаачид тус тус хариуцах, тайлан, түүн дэх ордын нөөцийн тооцоонд гаргасан шинжээчийн дүгнэлтийг Монгол Улсын мэргэшсэн геологич Н.Цэнгэлбаяр, хайгуулын ажлын үнэн бодит байдлыг “Талст молор” ХХК тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Б.ДАШПҮРЭВ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ХУРАЛДААНЫ ДАРГА  Х.САНЧИГДОРЖ

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Д.БААСАН

ЭБМЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдааны
Хэлэлцээний дүгээр буюу өргөмжлөлийн хавсралт

Оцог хад гянтболдын үндсэн ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт
(Ордын нөөц 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар)
Тусгай зөвшөөрлийн дугаар МВ-020930

Хүснэгт №1

Блокын дугаар	Жинхэнэ талбай	Блокын дундаж зузаан, м	Блокын эзэлхүүн, м ³	Эзэлхүүн жин, тн.м ³	Худрийн нөөц, тн	Дундаж агуулга, %, ХӨТ	Металл (W ₀) нөөц, тн, ХӨА
Худрийн биет №1							
I-B-1	13738.68	1.000	13738.68	2.66	36,469.93	0.39	142.31
I-B-2	9443.32	0.760	7176.52	2.66	19,061.90	0.48	91.50
I-B-3	1598.71	1.680	2685.83	2.66	7,133.56	0.68	48.51
Нийт В	24780.71	0.96	23601.43	2.66	62665.39	0.46	282.32
I-C-1	21832.83	0.630	13628.68	2.66	36,197.77	0.44	159.27
I-C-2	5323.05	0.810	4311.67	2.66	11,451.80	0.37	42.37
I-C-3	2435.92	1.450	3532.08	2.66	9,381.20	0.59	55.35
Нийт С	29591.80	0.73	21472.43	2.66	57,030.77	0.4600	266.99
Нийт В+С	54172.51	0.83	45073.86	2.66	119,716.16	0.4600	539.31
Худрийн биет №3							
III-B-1	9885.86	0.850	8385.98	2.66	22,273.16	0.43	95.77
Нийт В	9885.86	0.85	8385.98	2.66	22,273.16	0.43	95.77
III-C-1	8452.40	0.640	4129.54	2.66	10,968.06	0.62	68.00
III-C-2	8347.72	0.580	4841.68	2.66	12,859.50	0.48	61.73
Нийт С	14800.12	0.61	8971.22	2.66	23,827.56	0.54	129.73
Нийт В+С	24685.98	0.70	17367.20	2.66	46,100.72	0.49	225.50
Худрийн биет №4							
IV-B-1	1972.54	0.930	1834.46	2.66	4,872.33	0.52	25.34
IV-B-2	7959.90	1.330	10586.67	2.66	28,118.20	0.29	81.54
IV-B-3	7493.85	1.140	8542.99	2.66	22,690.18	0.30	68.07
IV-B-4	3306.69	1.160	3835.76	2.66	10,187.78	0.54	55.01
Нийт В	20732.98	1.20	24799.88	2.66	65,868.49	0.35	229.96
IV-C-1	17048.02	0.920	15684.18	2.66	41,657.18	0.43	179.13
IV-C-2	7280.97	1.350	9829.31	2.66	26,106.65	0.45	117.48
IV-C-3	3012.71	1.320	3976.78	2.66	10,562.33	0.61	64.43
Нийт С	27341.70	1.08	29490.27	2.66	78,326.16	0.46	361.04
Нийт В+С	48074.68	1.13	54290.15	2.66	144,194.65	0.41	591.00
Нийт В	56379.85	1.03	66787.29	2.66	180,827.04	0.40	608.05
Нийт С	71533.82	0.84	68933.92	2.66	189,184.49	0.47	747.78
Нийт В+С	128913.17	0.92	116721.21	2.66	310,011.53	0.44	1355.81



“ТАЛСТ МОЛОР” ХХК-Д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2018.09.06 № 13/5319
танай _____-ны № _____-т

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай**

Танай компаниас боловсруулж ирүүлсэн Ховд аймгийн Алтай сумын нутагт орших XV-019692 дугаартай тусгай зөвшөөрөлтэй “Оцог хад” нэртэй гянтболдын үндсэн ордыг ашиглах төсөлд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-ын 3 дахь хэсгийг үндэслэн, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын дагуу ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төсөлд шинээр батлагдсан аргачлалын хүрээнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулан 2018 оны 1 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Г.НЯМДАВАА

200500

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

**ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХУУДАС**

2017 оны 09-р сарын 04

Улаанбаатар хот

Төслийн дугаар

Дугаар 2017/Т-147

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Талст молор” ХХК, регистрийн дугаар-5774047, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13 дугаар хороолол, 1716-13 тоот.

Төслийн нэр: Гянтболдын үндсэн орд ашиглах

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Ховд аймгийн Алтай сумын нутагт орших XV-019692 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий талбайд хэрэгжинэ.

Холбоо барих утас: 976-99132103, 976-99079440

Орон нутгийн санал: Ховд аймгийн Алтай сумын Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 1/254 тоот саналыг харгалзав.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл, тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт			Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт	Тийм			
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх			Тийм	
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм	
Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм		

	Хөрсөн бүрхэвч				
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
	Ургамлан нөмрөг				
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	
	Амьтны аймаг				
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм	
	Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид			
		Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх			Тийм
Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх				Тийм	
Нөлөөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх				Тийм	
Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх				Тийм	
Түүх, соёлын биет өв					
Сөрөг нөлөөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх				Тийм	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл					
Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх				Тийм	
Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх				Тийм	
Нэгдсэн дүгнэлт:					
Ховд аймгийн Алтай сумын нутагт орших XV-019692 дугаартай тусгай зөвшөөрөлтэй “Оцог хад” гянтболдын үндсэн ордыг ашиглах төсөлд хийсэн Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.					
Онцгойлон анхаарах зүйлс:					
1.Гянтболдын орд ашиглах төслөөс байгаль орчинд учруулах нөлөөллийг нарийвчилсан үнэлгээний үндсэн дээр тодруулах замаар төслийг байгаль орчинд халгүй аргаар хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах;					
2.“Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-ын дагуу ордын үйл ажиллагаанаас ургамал, хөрс, ус, амьтан, агаар орчинд учруулах хохиролыг байгалийн бүрэлдэл тус бүрээр тогтоож, улмаар тухайн газрыг эвдрэлд оруулснаар учирч болох хохирлыг урьдчилан тооцож нийлбэр үнэлгээ гарган, төслийг хэрэгжүүлэх байгаль орчны хариуцлагын болон эдийн засгийн үндэслэлийг тодруулж дүгнэлт гаргах;					
3.Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг 5 жилээр боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг уурхайн хүчин чадал, уулын ажлын өрнөлтийн байдалтай уялдуулан тооцож төлөвлөх;					
4.Ордыг ашиглах явцад баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажиллагсадын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуйн талаар зөвлөмж, дүгнэлт боловсруулах;					
5. Уурхайн үйл ажиллагааны болон хаалтын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх болон холбогдох хууль тогтоомжийн дагуу орон нутагт хүлээлгэн өгөх ажлын графикчилсан төлөвлөгөө боловсруулах;					
6.Төсөл хэрэгжүүлж буй орон нутгийн багийн иргэдийн нийтийн хурлын саналыг авч тайланд хавсаргах, төслөөс байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, буруулах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулж, тайланд тусгах;					
7.Ашигт малтмал тээвэрлэх хатуу хучилттай замын төлөвлөлтийг тодруулж, тайланд тусгах;					

- 8.Төслийн үйл ажиллагаанд ашиглах химийн болон тэсэрч дэлбэрэх бодисын хэрэглээг эх үүсвэрийн хамт нарийвчлан тооцож, тайланд тусгах;
9.Байгаль орчны хамгаалах тухай” хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийх асуудлыг холбогдох зардлын хамт тайланд тусгах
10.Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд төслийн хүрээнд баригдах дэд бүтцийн барилга байгууламжийн зураг, төслийг нарийвчилсан үнэлгээний хүрээнд нэг бүрчлэн тодорхой болгож, барилгын ажлын явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтоож, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг шаардагдах зардлын хамт тайланд тусгах;
12.Ордын ашиглалт дууссаны дараах хаалтын нөхөн сэргээлтийн төсөл, хөтөлбөрийг уурхай хаахаас 2-оос доошгүй жилийн өмнө нарийвчлан боловсруулж иж бүрэн төлөвлөлт хийх;
13. Төслийн ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг гаргуулан тайланд хавсаргах;
14. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн маршрутыг тодруулж, тайланд тусгах;

Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурдсан арга хэмжээг цаг хугацаанд нь ханган биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн дагуу хариуцлага тооцохыг урьдчилан мэдэгдье.

Ерөнхий үнэлгээ хийсэн
Байгаль орчин, аялал жуулчлалын
яамны шинжээч



Д.ТЭМҮҮЛИН

Ерөнхий үнэлгээний үр дүнг
зөвшөөрсөн:
“Талст молор” ХХК-ийн захирал



Б.МӨНХТӨР



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,

E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

0018.01.04 № 068/77

танай _____-ны № _____-т

ТАЛСТ МОЛОР ХХК-Д

Ховд аймгийн Алтай сумын нутагт орших МУ-
020930 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл нь


Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан
бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий
газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох
тухай хуулийн 4.3, тус хуулийг дагаж
мөрдөх журмын тухай хуулийн 2.1-д заасны дагуу
Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор
баталсан Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан
бүхий газрын хилийн зааг, Засгийн газрын 2015 оны
289 дугаар тогтоолын Усны сан бүхий газрын энгийн
хамгаалалтын бүсийн хилийн заагтай тус тус
давхцалгүй байна.


Зурган мэдээллийг хавсаргав.




ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ
ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.БАТЗАЯА

00000016





ХААН БАНК		БАНК ХООРОНДЫН ШИЛЖҮҮЛЭГ / CLEARING SLIP		
Хүлээн авагчийн/Recipient's Information		Гүйцэтгэх өгнөө / Value Date: ОН/УУУУ 2020 САР/ММ 07 ӨДӨР/DD 01		
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN: 100900013406	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual: БУ НЕХЭН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Банкны нэр / Bank name: Төрийн Сан		
Валют / Currency: MNT	Дүн Тоогоор / Amount: *16,555,250.00*	Дүн үсгээр / Amount in words: *Арван зургаан сая таван зуун тавин таван мянга хоёр зуун тавин төгрөг*		
Шилжүүлгийн утга / Description: MV-020930 БОМТ-2020 ТАЛСТ МОЛОР ХХК		Шилжүүлгийн дараалал / Transaction queue:		
Шилжүүлэгчийн / Sender's Information				
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN: 5019492790	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual: ГАНБОЛД АЛТАНГЭРЭЛ			
Валют / Currency: MNT	Дүн Тоогоор / Amount: *16,555,250.00*	Дүн үсгээр / Amount in words: *Арван зургаан сая таван зуун тавин таван мянга хоёр зуун тавин төгрөг*		
Хүлээн авагчийн / Receiver's Information				
IBAN: 100900013406	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual: Төрийн Сан	Банкны нэр / Bank name:		
Шилжүүлэгчийн болон шилжүүлгийн мэдээлэл / Sender and transaction's Information:				
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN: 5019492790	Валют / Currency: MNT	Мөнгөний дүн / Amount: 16,555,250.00	Гарын үсэг, тамга / Signature, stamp:	
Шилжүүлгийн утга / Description: MV-020930 - БОМТ - 2020 ТАЛСТ МОЛОР ХХК				
Энэхүү баримтад бичигдсэн бүх мэдээлэл нь үнэн зөв болохыг доо гарын үсэг зурснаар баталгаажуулж байгаа бөгөөд аливаа хуулийн хариуцлагыг хүлээхээ үүгээр хүлээн зөвшөөрч байна. By signing in this form, I confirm the accuracy of the information provided here and agree to accept any legal responsibility.				
Банкны тэмдэглэл/For Bank use only				
Хураамж/Fee amount: 100	Журнал №/Journal №: 11680544	ХААН БАНК 18677-01	Банкны ажилтан №/Bank staff №: 18677	Огноо / Date: 2020/07/01
		Шилжүүлэгчийн регистрийн дугаар / Customer ID: 11680544/1191		

УЛААНБААТАР ХОТЫН БАНК  **ULAANBAATAR CITY BANK**

ОГНОО / DATE: 2018 07 04 САЛБАР / BRANCH: 2011 ЖУРНАЛ №: 7124100328

ХААНА АЖИЛТАЙ, ХЭНЭЭС / PAID BY FROM NAME / ORGANIZATION NAME: ТАЛСТ МОЛОР ХХК УТАСНЫ ДУГААР / PHONE NUMBER: 99948488

ОРЛОГО ХҮЛЭЭН АВАГЧИЙН НЭР / BENEFICIARY'S NAME: БС НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА


ХҮЛЭЭН АВАГЧИЙН БАНК / BENEFICIARY'S BANK: ТӨРИЙН САН ДАНСНЫ ДУГААР / ACCOUNT NUMBER: 100900013406

ДҮН (тоогоор) / AMOUNT (in figure): 5,370,000.00 ДҮН (үсгээр) / AMOUNT (in words): Таван сая гурван зуун дөнгөн мянган төгрөг

МӨНГӨНИЙ НЭГЖ / CURRENCY: MNT

ТӨЛБӨРИЙН ЗОРИУЛАЛТ / DETAILS OF PAYMENT: MV-020630 БОМТ-2018 ТАЛСТ МОЛОР ХХК РН 5774047 У 99948488

ТӨМӨЦГЭЛ / NOTE (Та дансны дугаар болон мөнгөн дүнгээ гаргаар бичнэ үү):

Бүтээгч / Issued by:  **БС-БАСАН ҮҮҮ Т.**

ХЯМАСХИ: **БС-БАСАН ҮҮҮ Т.**

ГҮҮЛГЭЭ ХИЙСЭН: 2018 оны 7 сар 04 өдөр

Бүтээгчийн үндсэн мэдээллийг уншж болохыг баталж өөрийн үсэг зурж / The undersigned hereby certifies that all information provided on this form is true and correct.

МӨНГӨ ТУШААГЧИЙН ГАРЫН ҮСЭГ: CUSTOMER'S SIGNATURE:

Гүйцэтгэлийн хураалт-100 төгрөг Банк хоорондын гүйцэтгэлийн хураалт-1000 төгрөг
 Мөнгөн дүнгээ гаргаар бичнэ үү / Банк хоорондын гүйцэтгэлийн хураалт-1000 төгрөг

ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ / DEPOSIT SLIP

ЗӨВХӨН БАННЫ ХЭРЭГЦЭЭНД FOR BANK USE ONLY		
МӨНГӨНИЙ НЭГЖ		
ДЭВСГЭРТ	ДЭВСГЭРТИЙН ТОО	ДҮН
1		
5		
10		
20		
50		
100		
500		
1000		
5000		
10000		
20000		
БҮГД		

ХААН БАНК Огноо/Date: 2022-03-07 16:19:58

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын /Journal No.: 17610398

Системийн огноо/System Date: 2022/03/07

Дг	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5026494890	ХАТАГТАЙ ЛХАГВА ШИЖИРГУУЯА	1,455,250.00 MNT	1.00
Кг	Банкны дугаар/Branch No 100900013406	Банкны нэр/Bank Name Төрийн Сан Нэр/Name БҮ нөхөн сэргээх баталгаа	1,455,250.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
нү-020930 бөмт-2022 талст молор ххк

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тосцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

Санамж: Бага дүнтэй (Таван сая төгрөг хүртэлх дүнтэй) гүйлгээ тухайн данс руу шууд шилжих бөгөөд таван сая төгрөгөөс дээш дүнтэй үед хүлээн авагчийн нэр, данс зөрөөл таны данс руу буцаж орно. Анжилттай гүйлгээний баримт таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу илгээгдэнэ. Ажлын өдрийн 16:00 цагаас хойш болон амралтын өдөр таарсан их дүнтэй (таван сая төгрөгөөс дээш дүнтэй) гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэхийг анхаарна уу

ХААН БАНК		БАНК ХООРОНДЫН ШИЛЖҮҮЛЭГ / CLEARING SLIP		
		ОН/УУУУ	САР/ММ	ӨДӨР/ДД
Хүлээн авагчийн/Recipient's Information		Гүйцэтгэх огноо / Value Date: 2023 04 07		
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN: 100900013406	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual: БУ НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Банкны нэр / Bank name: 5134		
Валют / Currency: MNT	Дүн Тоогоор / Amount: *23,305,250.00*	Дүн үсгээр / Amount In words: *Хорин гурван сая гурван зуун таван мянга хоёр зуун тавин төгрөг*		
Шилжүүлгийн утга / Description: 5774047 ТАЛСТ МОЛОР ХХК БОМТ БАРЬЦАА		Шилжүүлгийн дараалал / Transaction queue:		
Шилжүүлэгчийн / Sender's Information				
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN: 3026494890	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual: ХААН БАНК	Банкны нэр / Bank name:		
Валют / Currency: MNT	Дүн Тоогоор / Amount: *23,305,250.00*	Дүн үсгээр / Amount In words: *Хорин гурван сая гурван зуун таван мянга хоёр зуун тавин төгрөг*		
Хүлээн авагчийн / Receiver's Information				
IBAN: 100900013406	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual: БУ НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Банкны нэр / Bank name: 5134		
Шилжүүлэгчийн болон шилжүүлгийн мэдээлэл / Sender and transaction's Information:				
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN: 3026494890	Валют / Currency: MNT	Мөнгөн дүн / Amount: *23,305,250.00*	Гарын үсэг, тамга / Signature, stamp: /1. _____ / /2. _____ /	
Шилжүүлгийн утга / Description: 5774047 ТАЛСТ МОЛОР ХХК БОМТ БАРЬЦАА				
Энэхүү баримтад бичигдсэн бүх мэдээлэл нь үнэн зөв болохыг дор гарын үсэг зурснаар баталгаажуулж байгаа бөгөөд аливаа хуулийн хариуцлагыг хүлээхээ үүгээр хүлээн зөвшөөрч байна. By signing in this form, I confirm the accuracy of the information provided here and agree to accept all my legal responsibility.				
Банкны тэмдэглэл/For Bank use only				
Хураамж/Fee amount: 1500	Журнал №/Journal No: 14076897	Гарын үсэг/Signature: 19717-02	Банкны ажилтан №/Bank staff No: 19717	Огноо / Date: 2023/04/07
Шилжүүлэгчийн регистрийн дугаар / Customer ID: 78 8365968				


Огноо/Date: 2025-02-17 11:58:03

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction Information
Журналын /Journal No: 12852230
Гүйлгээний дугаар /PoId: 0

Системийн огноо/System Date: 2025-02-17

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5026494890	ХАТАГТАЙ ЛХАГВА ШИЖИРТУЯА	10,500,000.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No MOFUMNUB	Банкны нэр/Bank Name ТӨРИЙН САН		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 100900013406	Нэр/Name БО нөхөн сэргээх баталгаа	10,500,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
5774047 ТАЛСТ МОЛОР ХХК БОМТ БАРЬЦАА

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers



Овог, нэр/Fullname: Рэнцэнбат овогтой Мөнхтуяа / Munkhtuya Rentsenbat
Албан тушаал/Position: Гүйцэтгэх захирал / Chief executive officer
Баталгаажуулах код/Verification code:
XBNNZPESOPMLLCGH
Уг баримт бичиг нь Монгол Улсын "Цахим гарын үсгийн тухай" хуулийн 8.1 дугаар заалтын дагуу тамгыг орлох чадамжтай тоон гарын үсгээр баталгаажсан болно.
This document is verified by a digital signature that can replace an official stamp under the 8.1st clause of Mongolian Law on Digital Signatures.
Та <https://verify.khanbank.com/> вебсайт руу хандан дээрх 16 орон бүхий кодыг оруулснаар мэдээллийг шалгах боломжтой. Мөн уг холбоосоор дамжин цахим тоон гарын үсгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.
You can verify this document by going to <https://verify.khanbank.com/> and entering the 16-digit verification code provided. You can also find more information about digital signature on this page.

Санамж: Бага дүнтэй (Таван сая төгрөг хүртэлх дүнтэй) гүйлгээ тухайн данс руу шууд шилжих бөгөөд таван сая төгрөгөөс дээш дүнтэй үед хүлээн авагчийн нэр, данс зөрвөл таны данс руу буцан орно. Амжилттай гүйлгээний баримт таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу илгээгдэнэ. Ажлын өдрийн 16:00 цагаас хойш болон амралтын өдөр таарсан их дүнтэй (таван сая төгрөгөөс дээш дүнтэй) гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэхийг анхаарна уу





ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ДОТООД ШИЛЖҮҮЛГИЙН МАЯГТ / TRANSFER SLIP

ОН/УЕАР САР/MONTH ӨДӨР/DAY ЦАГ/TIME ЖУРНАЛ ДУГААР/JOURNAL № МӨНГӨНИЙ ДҮН (root/rop) /AMOUNT (in figure) МӨНГӨНИЙ НЭГЖ/CURRENCY

2026 03 16 13:25:08 957,100,912,774.00 15,175,000.00 MNT

ХААНААС:
FROM: ДАНС ЭЗЭМШИГЧИЙН НЭР / ACCOUNT HOLDER'S NAME:
ТАЛСТМОЛОР ХХК
ДАНСНЫ ДУГААР / ACCOUNT №: **MN620004000474081998**
РЕГИСТРИЙН № / PERSONAL ID №: **5774047**

МӨНГӨНИЙ ДҮН (үгээр) / AMOUNT (in words):
**АРВАН ТАВАН Сая нэг зуун даван
таван мянган төгрөг**

ХЭНД:
TO: ХҮЛЭЭН АВАГЧ БАНК / BENEFICIARY'S BANK:
Төрийн сан
ХҮЛЭЭН АВАГЧИЙН ОВОГ, НЭР / BENEFICIARY'S FULL NAME:
БО Нөхөн Сэргээх Баталгаа
ДАНСНЫ ДУГААР, МӨНГӨНИЙ НЭГЖ / ACCOUNT №, CURRENCY ШИМТГЭЛ / FEE:
MN780090100900013406 500.00

ТӨЛБӨРИЙН ЗОРИУЛАЛТ / PAYMENT DETAILS:
**ТАЛСТ МОЛОР ХХК 5774047 БОМТ
БАРЬЦАА**

ТЭМДЭГЛЭЛ:
NOTE: ЗАРЛАГА ТАРАХ ДАНСНЫ ДУГААР, МӨНГӨН ДҮН / SEND ACCOUNT №, AMOUNT:
474061998 15175000
ХҮЛЭЭН АВАГЧИЙН БАНК, ОВОГ НЭР, ДАНСНЫ ДУГААР, ДАНСНЫ ВАЛЮТ
BENEFICIARY'S BANK, FULL NAME, ACCOUNT NUMBER, CURRENCY:
**Төрийн сан БО Нөхөн сэргээх баталгаа
780090100900013406**

ТАМГА / STAMP, IF ANY: БАТАЛГААТ ГАРЫН ҮСЭГ / AUTHORIZED SIGNATURE:

САНАМЖ / NOTICE: Харилцагчийн буруугаас шилжүүлэг бүтээн тохиолдолд бусад өдрийн ханшаар буцаах гүйцэтгэл хийхийг анхаарна уу. Хамгийн зөрүүгээ алдагдал үүсэх тохиолдолд банк хариуцахгүй болно.

ЗӨВХӨН БАНКНЫ ХӨРВӨСӨНД / FOR BANK USE:
ХӨРВҮҮЛСЭН ХАНШ: **15,175,000.00** ХҮЛЭЭН АВСАН БАНКНЫ АЖИЛТАН:
ХӨРВӨСӨН ДҮН: ХЯНАСАН:
Маягт - 004

ХХБанк
Зайсан салбар
№02 Сар 03 Өдөр 16
Харилцагчийн
Төрийн сан ажигтан

"ТАЛСТ МОЛОР" ХХК НИЙ ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГТ
ХЭРЭГЖИХ НУТАГТ ОРШИХ "ОЦОГ ХАД" НЭРТЭЙ ГЯНТБОЛДЫН ҮНДСЭН
ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСӨЛ ТӨСЛИЙН 2025ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-020930
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5774047



ХЯНАСАН:
ХБОБХГ-ЫН АХЛАХ
ШИНЖЭЭЧ

О. АМАРСАНАА

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:
"ТАЛСТ МОЛОР" ХХК-
ИЙН ЗАХИРАЛ
"ТАЛСТ МОЛОР" ХХК-
ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНХТӨР
Ж.МӨНХСАЙХАН



2025 ОН